



Япон Улсын хилээр орох иргэдийн анхааралд (Шинжилгээний бичиг шалгуулах тухай)

Гадаадын улс орнуудад коронавирусийн мутацад орсон халдвар тархаж буй энэ цаг үед Японы Засгийн газар хилийн хорио цээрийн арга хэмжээг улам бүр чангатгаж энэхүү үйл ажиллагааны хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

- Хилээр орох бүх хүн (Япон улсын иргэнд хамааралтай), тухайн улсаас гарахдаа 72 цагийн дотор хамрагдсан шинжилгээний бичгийг өгөх шаардлагатай.
- Шинжилгээний бичиггүй хүнийг Хорио цээрийн тухай хуулийн дагуу Япон Улсын хилээр оруулахгүй.
 - Шинжилгээний бичиггүй бол агаарын хөлөгт суулгахгүй.
 - Хүндэтгэж үзэх шалтгааны улмаас зайлшгүй явах шаардлагатай хэдий ч шинжилгээний бичиг авч чадаагүй бол тухайн орны дипломат төлөөлөгчийн газарт хандах.
 - Энэхүү арга хэмжээ нь 2021 оны 3 дугаар сарын 19-ний өдрөөс хойш Япон Улсын хилээр орох иргэдэд хамааралтай.



1. Доорх шаардлагыг хангасан шинжилгээний бичиг хүчинтэйд тооцогдоно.

- Сорьц авсан өдөр, цагаас нисэх цаг хүртлэх хугацаа нь 72 цагийн дотор байх.
 - Тогтсон шинжилгээний бичгийн загварыг ашиглах
Эрүүл мэнд, хөдөлмөрийн яамны цахим хуудасаас дэлгэрэнгүй мэдээлэл авах →
- Шинжилгээний хариуны маягт татах ([Japanese](#) [English](#))
- Шинжилгээний бичигт доорх агуулгыг тусгах



①	Овог нэр, паспортын дугаар, иргэншил, төрсөн он сар өдөр, хүйс
②	Шинжилгээний аргачлал, сорьц (2, 3-т заасны дагуу)
③	Шинжилгээний хариу, сорьц авсан цаг өдөр, хариу гарсан өдөр, хариу олгосон өдөр
④	Эмнэлгийн байгууллагын нэр, хаяг, эмчийн нэр, байгууллагын тамга
⑤	Шинжилгээний бичгийг англи хэл дээр үйлдэнэ

2. Зөвхөн доорх оношилгооны аргуудыг хүчинтэйд тооцно

Вирусийн нуклейны хүчилд суурилсан шинжилгээ	Бусад
<ul style="list-style-type: none"> ■ real time RT-PCR real time reverse transcription PCR ■ LAMP Loop-mediated Isothermal Amplification ■ TMA Transcription Mediated Amplification ■ TRC Transcription Reverse-transcription Concerted reaction ■ Smart Amp Smart Amplification process ■ NEAR Nicking Enzyme Amplification Reaction 	<ul style="list-style-type: none"> ■ Next Generation Sequence ■ Quantitative Antigen Test[※] (CLEIA) ※ Antigen qualitative test биш.

3. Зөвхөн доорх сорьцоор авсан шинжилгээг хүчинтэйд тооцно.

- Хамар залгиурын арчдас
- Шүлс